



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/11

Жавхлант

Сумын аварга малчин өрхийг
шагнаж урамшуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сумын аварга малчин өрх”-өөр шалгарсан малчны шагналын төсвийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шагналд зарцуулах 1516000 (нэг сая таван зуун арван зургаан мянга)-н төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, (М.Шаравгаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Энхзаяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ЦОЛМОНБАЯР



Сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар
сарын 25-ны/ний өдрийн 11 тоот
захирамжийн I хавсралт



СУМЫН АВАРГА МАЛЧДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ТӨСӨВ

№	Шагналын төрөл	Зардлын дүн		
		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Таван эрдэнэ цом	3	135.000	405.000
2	Хүндэтгэлийн тууз	3	15.000	45.000
3	Цацлын хувин	3	30.000	90.000
4	Энгэрийн тэмдэг	6	5000	30.000
5	Өргөмжлөл	2	23.000	46.000
6	Мөнгөн шагнал	3	300.000	900.000
Нийт зардал				1.516.000